



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай


Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/03 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-уул Эрүүл мэндийн төвийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн эрх, үүргийг хоёрдугаар, эмнэлгийн цусны аюулгүй байдлыг үнэлэх хяналтын хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг чанарын албаны дарга /Э.Оюумаа/, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/ нарт үүрэг болгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулж Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 09 сарын 29-ны өдрийн А/87 дугаартай тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн
А/... тоот тушаалын нэгдүгээр хавсралт
29



ЦУС СЭЛБЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Дарга- Т.Гэрэлсүрэн-Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Нарийн бичгийн дарга- П.Тогтох-Эрдэнэ-хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч

Гишүүд- Т.Одонтунгалаг-хэвтэн эмчлүүлэх тасгийн чанарын багийн ахлагч

Ж.Биндэръяа-дотрын эмч

Б.Ариунзул - Эмийн сангийн эрхлэгч

С.Өлзийжаргал-ХӨТСА дарга

Ё.Бумдарь-Лабораторийн эрхлэгч

Ж.Лайла- дотрын эмч

Тасгийн ахлах сувилагч-Ч.Алтанцэцэг

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
7/29 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ЦУС СЭЛБЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн ажиллах бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагаа эрх үүргийг энэхүү журмаар зохицуулна.
2. Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий 9-10 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зохицуулах зөвлөлийн гишүүдэд хэвтэн эмчлүүлэх тасгийн чанарын багын ахлагч, эм зүй, эрчимт эмчилгээ, дотрын эмч, халдвар судлаач, лабораторийн эрхлэгч зэрэг мэргэжилтнийг оруулж ажиллана.
3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь гишүүдийн хурал байна.
4. Зөвлөлийн хурлыг улирал бүр, хяналт үнэлгээг хагас жил тутам хийнэ.
5. Зөвлөл нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталж, тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хүргүүлнэ.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

Зөвлөлийн бүрэлдэхүүн нь дараах ажил үүргийг хариуцаж ажиллана.

1. Цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэх үйл ажиллагаатай холбоотой тушаал заавар, стандартыг хэрэгжүүлэх, мэргэшсэн эмч мэргэжилтний ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтонд тусгах, зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, зөвлөлийн хурлыг хийх – Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

2. Хяналт үнэлгээ-цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээний байдалд хяналт үнэлгээ хийх-эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын албаны болон сувилахуйн албаны дарга, тасгийн эрхлэгч

3. Цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэх бүхий л үйл ажиллагаанд батлагдсан протокол, маягтыг бүрэн хөтлөх- эмчлэгч эмч, ахлах сувилагч

4.Цус сэлбэлтэнд оролцдог эмч, мэргэжилтнийг цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээ цус сэлбэлт, лаборатори, чанарын сургалтанд хамруулах- тасгийн эрхлэгч, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

5.Цус сэлбэлт үндэсний төвөөс цус цусан бүтээгдэхүүнийг авахдаа хүйтэн хэлхээний зөв нөхцөлд тээвэрлэлтийг хариуцах – ээлжи сувилагч

6.Өвчтний эмнэлзүйн байдал, цусны шинжилгээг үндэслэн өвчтөнд цус цусан бүтээгдэхүүн сэлбэх заалтыг эмчлэгч эмч гаргах ба сэлбэх зөвшөөрөл олгох -тасгийн эрхлэгч, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

7. Цус цусан бүтээгдэхүүний устгалд хяналт хийх- Халдвар судлаач эмч

8. Цус сэлбэх үйл ажиллагаанд хяналт хийх –Тасгийн эрхлэгч

9.Өвчтний сорьцыг лаборатори-т хүлээн авах, сорьцонд шинжилгээ хийж хариуг илгээх- лабораторийн эрхлэгч

10. Цус орлох шингэний хангамж, лабораторийн оношлуурын захиалга, хангамж- эмийн сангийн эрхлэгч

11. Цус цусан бүтээгдэхүүний тайланг гаргах- цус хариуцсан эмч, ахлах сувилагч

Гурав.Зөвлөлийн эрх, үүрэг

1.Цус цусан бүтээгдэхүүн, цусны бэлдмэл, цус орлох шингэний хангамж, аюулгүй байдлыг хариуцан ажиллана.

2.Эмнэлгийн тасаг нэгжүүдэд шаардлагатай цус цусан бүтээгдэхүүний хэрэглээг бүртгэж, хэрэгцээг жил, улирлаар тооцож гаргана.

3.Цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээнд эмнэлзүйн сайн дадлыг нэвтрүүлнэ.

4. Цус сэлбэх үйл ажиллагааг бүрэн баримтжуулан, хяналт үнэлгээ хийж тасралтгүй сайжруулж ажиллана.

5.Эмнэлэгт хийгдэж байгаа цус сэлбэлттэй холбоотой үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, сар улирлаар статистик мэдээлэлийг нэгтгэн баримтжуулна.

6.ЦЦБ-ний зохимтой хэрэглээ, аюулгүй цус сэлбэлтийн талаар ажлын байрны болон богино хугацааны сургалтанд эмч, мэргэжилтнийг хамруулна.

7. Цус сэлбэлттэй холбоотой тулгамдсан асуудлыг эрүүл мэндийн газар, эмнэлгийн удирдлагуудад хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

8. Зөвлөлийн бүрэлдэхүүний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр дотоодын болон олон улсын хурал, семинар, сургалтанд хамруулна.

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
2018 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн
1/24 тоот тушаалын гурав дугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дэмжлэгт хяналт хийсэн он сар өдөр:

Хяналт хийсэн албан тушаалтан:

1. Цус сэлбэлтийн зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаа

№	Мэдээллийн эх сурвалж	Тайлбар	Гүйцэтгэл
1	ЦСЗ байгуулсан тушаал, бүрэлдэхүүн		
2	Гишүүдийн ажил үүргийн хуваарилалт		
3	ЦСЗөвлөлийн хурал улирал тутам хийсэн эсэх		
4	Ажлын төлөвлөгөө		
5	Тайлан мэдээ хүргүүлсэн байдал		
6	Цусны хэрэгцээг жил улирлаар тооцдог эсэх		
7	Цусны зохистой хэрэглээ сургалт		
8	Гүйцэтгэлийн хувь		

2. Лабораторийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас

№	Мэдээлэлийн эх сурвалж	Тайлбар	Гүйцэтгэл
1	Цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох шинжилгээ хийдэг эсэх		
2	Сургагдсан эмч лаборантын тоо		
3	Тоног төхөөрөмжийн хангалт баталгаа тохируулга ажлын заавар		
4	Урвалж бодисын хангалт чанарын гэрчилгээ хуруу шил		
5	Шинжилгээний арга аргачлал, мөрдөлт		
6	Протокол баримтжуулалт хариу илгээх маягтын хөтлөлт		
7	Лабораторит сорьц хүлээж авах үйл ажиллагааг ЭМС-ын А/03 тоот тушаалын хавсралт 7 үзүүлэлтээр		
8	Гүйцэтгэлийн хувь		

3.Тасаг нэгжийн бэлэн байдал

№	Мэдээлэлийн эх сурвалж	Тайлбар	Гүйцэтгэл
1	Зохистой хэрэглээний үндэсний удирдамж ашиглаж байгаа эсэх		
2	ЦЦБ сэлбэх зөвшөөрөл авах маягт ЦЦБ захиалах сэлбэсэн протокол хөтлөлт урвал хүндрэл бүртгэх мэдээлэх маягт		
3	Цусны бүлэг тодорхойлох боломж бүрдсэн эсэх		
4	Сорьц авах илгээх журам		
5	Яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдал		
6	ЦЦБ хэрэглээ хэрэгцээ тооцдог эсэх		
7	ЦЦБ эмчилгээний үр дүнг тооцож үнэлдэг		
8	ЦЦБ сэлбэх систем бусад шаардлагатай зүйлсийн бэлэн байдал		
9	Гүйцэтгэлийн хувь		

4.ЦЦБ-ний хадгалалт тээвэрлэлт

№	Мэдээлэлийн эх сурвалж	Тайлбар	Гүйцэтгэл
1	ЦЦБ тээвэрлэх зориулалтын сав шаардлага хангаж байгаа эсэх		
2	Хариуцсан ажилтан томилсон эсэх		
3	Тээвэрлэлтийн байдал		
4	Сорьц авах илгээх журам		
5	ЦЦБ хадгалах хөргөгч хөлдөөгч байгаа эсэх		
6	Хадгалалтын хэм хяналтын карт хөтлөлт хийдэг эсэх		
7	ЦЦБ эмчилгээний үр дүнг тооцож үнэлдэг		
8	Гүйцэтгэлийн хувь		

5.Цус сэлбэх үйл ажиллагаа-Өвчний түүхтэй танилцаж үнэлгээ өгөх

№	Мэдээллийн эх сурвалж	Тайлбар	гүйцэтгэл
1	Паспортын хэсэг дээр АВО бүлэг тодорхойлогдсон, биеийн жин бичигдсэн		
2	Зөвшөөрлийн маягт захиалгын маягт зэрэг сэлбэх протокол ЭМСайдын А/03 тушаалын дагуу эмчилгээний үр дүнг хавсралтаар үнэлэх		
3	Өвчний эмнэлзүйг тодорхойлсон динамик явц үндэслэл бодит үзлэг		
4	Гүйцэтгэлийн хувь		